



ТӨВ АЙМГИЙН  
БҮРЭН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 03 сарын 04 өдөр

Дугаар 08

Баянтөхөм

Хоршоог хөгжүүлэх сангийн зээлийн дээд, доод хэмжээг тогтоож, тэргүүлэх чиглэл батлах тухай

Сум хөгжүүлэх сан нь хоршоо хөгжүүлэх сан болж өөрчлөгдсөнтэй холбогдуулан сангаас зээл олгох дээд, доод хэмжээг шинэчлэх, тэргүүлэх чиглэлийг батлах талаар сумын Засаг дарга Т.Түвшинбатын мэдээллийг хэлэлцээд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дүгээр зүйлийн 48.1 дэх хэсэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын А/361 дүгээр тушаалаар батлагдсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.3.1 дэх заалт, 3.3.4 дахь заалт, аймгийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/94 дүгээр захирамжийг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зургаадугаар хуралдаанаар ТОГТООХ нь:

- 1.Хоршоог хөгжүүлэх сангаас нэг төсөлд олгох зээлийн дээд хэмжээг 50.000.000 /Тавин сая/, доод хэмжээг 10.000.000 /Арван сая/ төгрөгөөр тус тус тогтоосугай.
- 2.2022 онд зээл олгох “Тэргүүлэх чиглэл”-ийг хавсралтаар баталсугай.
- 3.Аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, цаашид хэрэгжүүлэх зорилт, хөтөлбөр, төлөвлөгөө, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан зээл олгож, шинээр ажлын байр нэмэгдүүлэн ажиллахыг Төсөл сонгон шалгаруулах хороонд үүрэг болгосугай.
- 4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.


ДАРГА



С.ЭНХТҮВШИН

41220429


Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2022 оны 03 сарын 04 ний өдрийн VI хуралдааны  
08 дугаар тогтоолын хавсралт



## 2022 ОНЫ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

### Төслийн чиглэл нь:

- ❖ Мах бэлтгэл, махан бүтээгдэхүүн;
- ❖ Дайвар бүтээгдэхүүн;
- ❖ Мал бордох аж ахуй;
- ❖ Түүхий эдийн анхан шатны боловсруулалт
- ❖ Стандартын мал нядалгааны шугам
- ❖ Хөдөө, аж ахуйн үйлдвэрлэл





ТӨВ АЙМГИЙН  
БҮРЭН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 03 сарын 04 өдөр

Дугаар 07

Баянтөхөм

Төсөл сонгон шалгаруулах хороо,  
Хяналтын зөвлөл байгуулах тухай

Сум хөгжүүлэх сан нь хоршоо хөгжүүлэх сан болж өөрчлөгдсөнтэй холбогдуулан төсөл сонгон шалгаруулах хороо болон хяналтын зөвлөлийг байгуулах талаар сумын Засаг дарга Т.Түвшинбатын мэдээллийг хэлэлцээд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсэг, 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын А/361 дүгээр тушаалаар батлагдсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.6 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.3.2 дахь заалт, 4 дүгээр зүйлийн 4.2, 4.3 дахь хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зургаадугаар хуралдаанаар ТОГТООХ нь:

1.Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах хороог нэгдүгээр хавсралтаар, зэлийг эргэн төлүүлэх, хяналт тавих хяналтын зөвлөлийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Хороо болон хяналтын зөвлөл нь А/361 дүгээр тушаалаар батлагдсан журмын дагуу эрх, үүргийг хэрэгжүүлэхэд нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Засаг дарга (Т.Түвшинбат)-д даалгасугай.

3.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 07 дугаар сарын 07 ны өдрийн 05, 06 дугаар тогтоолуудыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.


ДАРГА



С.ЭНХТҮВШИН

41220426

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2022 оны 03 сарын 04 ний өдрийн VI хуралдааны  
07 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



## ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ХОРОО

Хорооны дарга:

-Засаг даргын Тамгын газрын дарга

Нарийн бичгийн дарга:

-Хүнс, Жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал  
хариуцсан мэргэжилтэн


Гишүүд:

- Санхүү албаны дарга
- Төрийн бус байгууллагын төлөөлөгч
- Төрийн бус байгууллагын төлөөлөгч



---oOo---

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2022 оны 03 сарын 04 ний өдрийн VI хуралдааны  
07 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



## ЗЭЭЛИЙГ ЭРГЭН ТӨЛҮҮЛЭХ, ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ

Зөвлөлийн дарга:

-ИТХ дахь цөөнхийн бүлгийн төлөөлөгч

Нарийн бичгийн дарга:

-Хүнс, Жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал  
хариуцсан мэргэжилтэн

Гишүүн:

-Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн  
-Аймгийн Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны  
асуудал хариуцсан мэргэжилтэн  
-Төрийн бус байгууллагын төлөөлөгч